Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 240,311.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4,806.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,364.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд суурь өөрчлөөгүй 1,724.3 мянган төгрөгөөр материаллаг байдал нэмэгдүүлэх зөрүү үүссэн. Тиймээс ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэж төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлаар тогтоов.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55,975.5 мянган төгрөгөөр буюу 12.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | 2020.12.31 | 2021.12.31 | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| Байгууллагаас авах авлага | - | 14.9 | 14.9 | 100.0 |
| Урьдчилж гарсан зардал | - | 7,200.0 | 7,200.0 | 100.0 |
| Бараа материал | 183,634.2 | 179,080.8 | (4,553.4) | 97.5 |
| Үндсэн хөрөнгө | 244,661.3 | 190,269.1 | (54,392.2) | 77.8 |
| Нийт хөрөнгө | 432,540.4 | 376,564.8 | (55,975.5) | 87.1 |
| Өр төлбөр | - | 11,196.8 | 11,196.8 | 100.0 |
| Засгийн газрын хувь оролцоо | 432,540.4 | 365,368.0 | (67,172.3) | 84.5 |
| Нийт өр төлбөр, өмчийн дүн | 432,540.4 | 376,564.8 | (55,975.5) | 87.1 |

Тус байгууллага нь Төрийн санд үндсэн болон нэмэлт санхүүжилтийн 2 данстай.

Үндсэн санхүүжилтийн харилцах 100210019005 тоот дансаар 292,468.7 мянган төгрөгийн санхүүжилт, 7,745,3 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүний 292,468.7 мянган төгрөг нь санхүүжилтийн орлого, 6,546.6 мянган төгрөг нь үйлчилгээний

орлого,1,198.7 мянган төгрөг нь нэр данс зөрүүтэй ажил гүйлгээнээс үүссэн орлого байна. Эдгээр мөнгөн орлогоос 1,198.7 мянган төгрөгийн нэр данс зөрүүтэй гүйлгээ залруулагдаж, 287,707.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж, үлдэгдэл 11,057.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, уг данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Нэмэлт санхүүжилтийн 100210019405 тоот дансаар 38,880.5 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого, 7,162.5 мянган төгрөгийн орлого орсон байна. Санхүүжилтийн орлого нь орон нутгийн төсвийн орлогоос ариутгал халдваргүйжил хийх зардалд 19,270.0 мянган төгрөг, вакцины тарилгын хөлс 14,000.0 мянган төгрөг, тандалт судалгааны ажлын хөлс 5,610.5 мянган төгрөг, шинжилгээний орлого 150.0 мянган төгрөг, нийт 39,030.5 мянган төгрөг, нэр данс зөрүү 7,012.5 мянган төгрөг зэргээс бүрдсэн байна. Нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааны зардалд 38,820.6 мянган төгрөг зарцуулж, 7,012.5 мянган төгрөг нэр данс зөрүүг залруулсан, 209.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, уг данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Авлага дансны 14.9 мянган төгрөг нь Эрдэнэт-Ус ОНӨХК-аас авах авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Урьдчилж гарсан зардлаар бүртгэгдсэн 7,200.0 мянган төгрөг нь "Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын энэ оны урсгал санхүүжилтийн зардлын бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал бүлэгт мэдээлэл, технологийн үйлчилгээ нэртэй 10,800.0 мянган төгрөгийн зардал нэмж тодотгон зардлын эрх нээсэн байна.Тодотгон баталсан зардлыг 2021 оны 12 дугаар сарын 20-ны 360 дугаартай төлбөрийн хүсэлтээр "Дата ланд технологи" ХХК-нд "*программ хангамжийн үнэ төлөв Орхон МЭГ*" утгатайгаар шилжүүлсэн байна. Шилжүүлсэн төлбөрийг Мал эмнэлгийн ерөнхий газраас ирсэн зааварчилгааны дагуу 3,600.0 мянган төгрөгийг зардалд, 7,200.0 мянган төгрөгийг санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардлаар бүртгүүлсэн байна. Гэрээнд программ хангамжийн үйлчилгээний хөлсийг сард 600.0 мянган төгрөг жилд 7,200.0 төгрөг төлөхөөр тусгасан байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 2.5%-аар буюу 4,553.4 мянган төгрөгөөр буурсан байна. Уг бууралтад дараах бараа материалуудын хөдөлгөөн нөлөөлсөн байна. Үүнд:

- Тусгай зориулалтын бараа материал энэ онд 380.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 47.3 мянган төгрөгийн зарцуулалт хийж үлдэгдэл өмнөх оноос 332.7 мянган төгрөгөөр өссөн
- Эм боох материалын үлдэгдэл өмнөх онд 152,306.2 мянган төгрөг энэ оны эцсийн үлдэгдэл 142,914.4 мянган төгрөг болж 9.4 мянган төгрөгөөр буурсан. Энэ үлдэгдэл нь 18 нэр төрлийн 70,793.1 мянган төгрөгийн лабораторийн эм урвалж бодис, 18 нэр төрлийн 40,868.9 мянган төгрөгийн тусгай зориулалтын багаж хэрэгслээс бүрдэж байна.
- Бичиг хэргийн материал өмнөх онд 2,350.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан энэ онд 3,071.2 мянган төгрөг болж үлдэгдэл 721.0 мянган төгрөгөөр өссөн. Бичгийн цаас 37 ширхгийг 536.5 мянган төгрөгөөр авч нөөц үүсгэсэнтэй холбоотой байна.
- Аж ахуйн материал өмнөх оноос өссөн нь 262.9 мянган төгрөгийн нэг удаагийн амны хаалт авч үлдэгдэл нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.
- Сэлбэг хэрэгслийн материалын үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна. Уг үлдэгдэлд дугуй, аккумлятор зэрэг үндсэн хөрөнгөнд тусад нь бүртгэж Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалд заасан нормоор элэгдүүлэх хөрөнгө бүртгэгдсэн байна.
- Бусад хангамжийн материалын үлдэгдэл өмнөх оноос өссөн нь малын шүлхийн өвчний вакцины энэ онд татан авснаас 5000 нэгж буюу 4,102.6 мянган төгрөг үлдэгдлээр бүртгэгдсэнтэй холбоотой өсөлт байна. Нэг удаагийн халдвар хамгаалын хувцас өмнөх онд 100 ширхэг 1,450.0 мянган төгрөгөөр үлдэгдэлтэй байсан энэ онд хөдөлгөөн хийгдээгүй мөн үлдэгдлээр үлдсэн байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 32.2%-аар буюу 54,392.2 мянган төгрөгөөр буурсан нь 2,199.9 мянган төгрөгийн 1 ширхэг компьютер худалдан авснаар нэмэгдэж тайлант жилийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Өр төлбөрийн дансны өөрчлөлт нь 7 мал эмнэлгт вакцин тарилтын үйлчилгээний хөлс болох 11,196.8 мянган төгрөг орон нутгийн санхүүжилтээс дутуу батлагдаж ирсэнтэй холбоотой өр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 67,172.3 мянган төгрөгөөр буюу 15.5%-аар буурч 365,368.0 мянган төгрөг болжээ. Үүнд тайлант үеийн үр дүн 67,172.3 мянган төгрөгөөр алдагдалтай гарсан нь нөлөөлсөн байна.

*Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | 2020 он | 2021 он | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,377.3 | 6,546.7 | (830.6) | 88.7 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 128,482.1 | 167,121.8 | 38,639.7 | 130.1 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 308,793.4 | 292,468.7 | (16,324.7) | 94.7 |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,068.0 | 33,270.0 | (4,798.0) | 87.4 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,297.4 | 5,610.5 | (10,686.9) | 34.4 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 150.0 | 150.0 | |
| Нийт орлого | 499,018.2 | 505,167.7 | 6,149.5 | 101.2 |

2021 онд тус байгууллагын нийт орлого өмнөх оноос 6,149.5 мянган төгрөгөөр буюу 1.2%-аар өссөн байна. Үүнд, Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал хөрөнгийн орлого 30.1 хувь буюу 38,639.7 мянган төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Орлогыг нэр төрөл тус бүрээр шинжилбэл дараах байдалтай байна. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагаанаас орсон орлого буюу лабораторийн орлого өмнөх оноос 11.3%-аар буюу 830.6 мянган төгрөгөөр буурсан нь үйлчилгээний салбар цар тахалтай холбоотой үйл ажиллагаа зогсонги байсантай холбоотой байна.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөн нь энэ онд үхрийн халдварт өвчин гарсантай холбоотой 63,426.9 мянган төгрөгийн вакцин, 100,776.3 мянган төгрөгийн эм боох материал, 2063.5 мянган төгрөгийн түлш шатахуун, 630.0 мянган төгрөгийн бараа материал үнэгүй нийлүүлсэнтэй холбоотой өссөн байна.
- Орон нутгийн нөөцөөс хуваарилсан хөрөнгө 4,798.0 мянган төгрөгөөр буюу 12.6%-аар буурсан нь батлагдсан санхүүжилт бүрэн ирээгүйтэй холбоотой байна.
- Орон нутгаас ирэх санхүүжилт 10,686.9 мянган төгрөг буюу 65.6%-аар буурсан байна.

*Хүснэгт 4. Зардлын үзүүлэлт /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | 2020 он | 2021 он | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 362,096.1 | 335,846.0 | (26,250.2) | 92.8 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 362,096.1 | 335,846.0 | (26,250.2) | 92.8 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 335,267.1 | 322,412.3 | (12,854.9) | 96.2 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 50,575.6 | 182,423.1 | 131,847.5 | 360.7 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 6,827.8 | 23,730.2 | 16,902.4 | 347.6 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 40,776.7 | 39,936.1 | (840.6) | 97.9 |
| Хангамж, бараа материалын зардал | 10,243.1 | 12,905.5 | 2,662.3 | 126.0 |
| Нормативт зардал | 13,015.2 | 16,617.1 | 3,601.9 | 127.7 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 7,775.6 | 1,548.6 | (6,227.0) | 19.9 |
| Томилолт, зочны зардал | 2,144.2 | 3,675.3 | 1,531.1 | 171.4 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 203,909.0 | 41,326.4 | (162,582.6) | 20.3 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | - | 250.0 | 250.0 | |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 26,829.0 | 13,433.7 | (13,395.3) | 50.1 |
| Бусад урсгал шилжүүлэг | 1,098.0 | 1,916.0 | 818.0 | 174.5 |
| Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 25,731.0 | 11,517.7 | (14,213.3) | 44.8 |
| Дотоод эх үүсвэрээр хөрөнгө худалдан авсан зардал | 8,439.9 | 2,200.0 | (6,239.9) | 26.1 |

Нийт зардал өмнөх оноос 7.2%-аар буюу 26,250.2 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд үйл ажиллагааны бус зардал гараагүй байна. Үйл ажиллагааны зардлын бууралтын нөлөөлөл нь:

- ✓ Бараа, ажил үйлчилгээний зардлын бууралтад Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын бууралт 79.7%-аар буюу 162,582.6 мянган төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшил 260.7%-аар буюу 131,847.5 мянган төгрөгөөр өссөн 2-ын зөрүүгээр бууралт үүссэн, Эд хогшил урсгал засварын

зардал 80.1%-аар буюу 6,227.0 мянган төгрөгөөр буурсан зэрэг нь нөлөөлсөн байна.

- ✓ Урсгал шилжүүлгийн зардлын бууралт Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг өмнөх оноос 55.2% буюу 14,213.3 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг өмнөх оноос 73.9%-аар буюу 6,239.6 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар Засгийн газрын хувь оролцооны нийт дүн 67,172.3 мянган төгрөгөөр буюу 13.4%-аар буурсан нь тайлант оны алдагдал нөлөөлсөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төлөвлөлтийг хийхдээ өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан төсвийн төсөл боловсруулж Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлдэг. Төсвийн төслийг хийхдээ бүлгийн дүн зөрүүтэй, тооцоолол алдаатай хийсэн байх тул харьцуулсан шинжилгээ хийхэд алдаатай үзүүлэлт гарч байна.

Анхны батлагдсан төсөвт 2021 оны 11 дүгээр сард нэмэлт тодотгол хийлгэхдээ зөвхөн зардлын жагсаалт тайлбарын хамт Мал эмнэлгийн ерөнхий газарт илгээсэн байна.

Батлагдсан төсвийн зарлага болох 292,468.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталжээ.

Тус байгууллагын 2021 оны төсөвт зардал, уг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь 2021 оны байдлаар 292,468.6 мянган төгрөг болж тодотгосон төсвийн дүн өмнөх оны төлөвлөгөөнөөс 44.1%-аар буюу 89,495.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Оны төгсгөлд татан төвлөрүүлсэн дүнгээс харахад гэрэл цахилгааны зардал 1,000.0 мянган төгрөгөөр 11 сард тодотгосон боловч жилийн төгсгөлийн дүнгээр цахилгааны зардлаас 1,174.8 мянган төгрөг татан төвлөрүүлсэн байгаа нь үндэслэл тооцоог хангалтгүй хийснийг харуулж байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 292,468.6 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 287,707.6 мянган төгрөг буюу 98.4% байна. Төсвийн гүйцэтгэлийн хэлбэлзлийг дараах хүснэгтээр харууллаа.

*Хүснэгт 6 Төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлт /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 292,468.6 | 287,707.6 | 4,761.0 | 98.4 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 290,552.6 | 285,791.6 | 4,761.0 | 98.4 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 183,679.0 | 182,423.1 | 1,255.9 | 99.3 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,730.2 | 23,730.2 | 0.0 | 100.0 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 42,845.8 | 39,936.1 | 2,909.7 | 93.2 |
| Хангамж, бараа материалын зардал | 9,161.0 | 9,157.7 | 3.3 | 100.0 |
| Норматив зардал | 4,700.6 | 4,589.2 | 111.4 | 97.6 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 3,642.8 | 3,634.5 | 8.3 | 99.8 |
| Томилолт, зочны зардал | 550.0 | 441.0 | 109.0 | 80.2 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 21,993.2 | 21,629.8 | 363.4 | 98.3 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 250.0 | 250.0 | - | 100.0 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,916.0 | 1,916.0 | - | 100.0 |
| Бусад урсгал шилжүүлэг | 1,916.0 | 1,916.0 | - | 100.0 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 292,218.7 | 281,160.9 | 11,057.8 | 96.2 |
| ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 292,218.7 | 281,160.9 | 11,057.8 | 96.2 |
| Орон нутгийн төсвөөс | 292,218.7 | 281,160.9 | 11,057.8 | 96.2 |

Тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас 1,255.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 2,909.7 мянган төгрөгийн, хангамж, бараа материалын зардлаас 3.3 мянган төгрөг, нормативт зардлаас 111.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлаас 8.3 мянган төгрөг, томилолт, зочны зардлаас 109.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 363.4 мянган төгрөгийн төсвийн хэмнэлт үүссэн байна. Үүний үр нөлөөгөөр төсөвт зардал 1.6%-аар хэмнэгджээ. Харин улсын төсвөөс тайлант онд гүйцэтгэлээр 292,218.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоос 6,296.8 мянган төгрөг олж, үүнээс 281,160.9 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 11,057.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлого**

Мал эмнэлгийн ерөнхий газраас орон нутгийн Мал эмнэлгийн газруудад үйлчилгээний орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр жил бүр 2,000.0 мянган төгрөгөөр баталж өгдөг байна. Орхон аймгийн Мал эмнэлгийн газар энэ оны төлбөрт үйлчилгээний орлогын төлөвлөгөөг 6,546.6 мянган төгрөгөөр биелүүлж орлогын тайланд тусгаж Улсын төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

| № | Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Өөрчлөлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Лаборторийн шинжилгээний орлого | 2,000.0 | 6,546.6 | 4,546.6 | 327.3 |

Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 11 дугаар тогтоолоор мал эмнэлгийн ажил үйлчилгээний жишиг үнэлгээг тогтоосон байна.

Лабортарийн үйлчилгээний орлогыг Мал эмнэлгийн ерөнхий газрын хэмжээнд ашиглаж байгаа vetlab.shinjilgee.mn цахим мэдээллийн санд шинжилгээ тус бүрээр шивж оруулан дээжийн бүртгэлийн дугаараар хэвлэж олгодог. Тиймээс цахим программаас гарсан шинжилгээ бүрийн төлбөр тус газрын үндсэн данс руу шилжиж орж сар бүр улсын төсвийн орлогын дансанд төвлөрүүлж байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дах заалтад “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн төсвийн орлогоос ариутгал халдваргүйжил хийх зардалд 19,270.0 мянган төгрөг, вакцины тарилгын хөлс 14,000.0 мянган төгрөг, тандалт судалгааны ажлын хөлс 5,610.5 мянган төгрөг, шинжилгээний орлого 150.0 мянган төгрөг, нийт 39,030.5 мянган төгрөг төвлөрүүлсэн. Уг санхүүжилтээс тарилгын хөлсөнд 19,696.6 мянган төгрөг, шатахууны зардалд 3,747.8 мянган төгрөг, томилолтын зардалд 3,234.3 мянган төгрөг, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардалд 12,027.9 мянган төгрөг, хөдөлмөр хамгааллын зардалд 114.0 мянган төгрөг тус тус зарцуулж, 209.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын хийх явцад аудитын баг холбогдох нотлох баримтыг саадгүй авч ашигласан бөгөөд тайлант оны санхүүгийн ажил гүйлгээ санхүүгийн тайланд толилуулсан мэдээллийн хүрээнд аудит хийгдсэн.

## 3.8 Аудитын гол асуудал

*Үндсэн хөрөнгийн дараа үеийн хэмжилттэй холбоотой асуудал*

Орхон аймгийн мал эмнэлгийн газрын дансанд бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгийн дансанд 330,957.8 мянган төгрөгийн түүхэн өртөгтэй, 144 нэр төрлийн машин, тавилга эд

хогшил, тоног төхөөрөмж гэх мэт эргэлтийн бус хөрөнгө байгууллагын хяналтад оршиж, ашиглагдсаар байна. Энэ нь тус байгууллагын үндсэн хөрөнгийн 54.3 хувийг эзэлж байна.

УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-ийн 44 дугаар параграф "*хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж, тусгана. Тайлангийн өдрөөрх бодит үнэ цэнийг ашигласнаар тодорхойлсон дүнгээс дансны үнэ нь материаллаг зөрүүгүй гэдгийг хянан магадлахын тулд дахин үнэлгээг хангалттай тогтмол хийдэг байвал зохино.*", 49 дүгээр параграф "*Дахин үнэлгээний давтамж нь дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалдаг. Дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит бодит үнэ цэнэ нь түүний дансны үнээс материаллаг өөр болсон тохиолдолд дараагийн дахин үнэлгээг хийх шаардлагатай байдаг*", 51 дүгээр параграф "*хэрэв үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлэх бол тухайн хөрөнгийн харьяалагдаж буй үндсэн хөрөнгийн нийт ангийг дахин үнэлнэ*" гэж тус тус заажээ. Стандартын дээрх заалтуудаар тоног төхөөрөмж, тавилга эд хогшил гэсэн хөрөнгийн ангид байгаа хөрөнгүүдийн дансны үнэ нь бодит үнэ цэнээсээ материаллаг ялгаатай үед тухайн ангид байгаа бүх хөрөнгийг дахин үнэлэхийг шаардаж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 дугаарт "*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох*" гэж заасан байна.

Эдгээр стандарт болон хуулийн заалтуудад нийцүүлэн дээрх хөрөнгүүдийг үндсэн хөрөнгийн ангиар нь дахин үнэлж, нягтлан бодох бүртгэлд тусгах бодит хэрэгцээ, шаардлага байгааг бүх шатны төсвийн захирагч нар анхаарах нь зүйтэй юм.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хэрэгжилтийг авч үзвэл, тайлант хугацаанд оруулбал зохих төсөв гүйцэтгэлийн 49, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалттай холбоотой 39, бусад 61, нийт 149 төрлийн мэдээлэл байршуулснаас 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

*Төсвийн төлөвлөлт ба зохицуулалтын талаарх асуудал*

- Тайлант хугацаанд Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын батлагдсан төсвийн хуваарьт 1 удаа өөрчлөлт оруулсан гэсэн тайлбар жагсаалтаас өөр нотлох баримт байхгүй байна. Уг жагсаалтыг үндэслэн нэмж тодотгосон зарим зардал оны эцэст буцаан татан төвлөрүүлсэн байна. Төсвийн тодотгол хийхдээ Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.2-т заасан төсөвт зохицуулалт хийх шаардлага, нарийвчилсан тооцоо тайлбар хийсэн баримт бичгийг бүрдүүлж төсвийн зохицуулалт хийж байх шаардлагатайг анхаарах нь зүйтэй байна.

Энэ асуудал нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт "*Төсвийн тогтвортой байдлыг хангасан байх*", Сангийн сайдын 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 134 дүгээр тушаал "*Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам*"-ын 3.1, 3.2 дахь заалтад бүрэн нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна гэж дүгнэлээ.

- Мал эмнэлгийн ерөнхий газар нь Орхон аймгийн Мал эмнэлгийн газрын энэ оны урсгал санхүүжилтийн зардлын бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал бүлэгт мэдээлэл, технологийн үйлчилгээ нэртэй 10,800.0 мянган төгрөгийн зардал нэмж тодотгон зардлын эрх нээсэн байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын заавраар Тодотгон баталсан зардлыг 2021 оны 12 дугаар сарын 20-ны 360 дугаартай төлбөрийн хүсэлтээр “Дата ланд технологи” ХХК-нд программ хангамж ашигласны төлбөрт 10,800.0 мянган төгрөгийг бүрэн шилжүүлсэн. Гэрээнд программ хангамж ашигласан үйлчилгээний хөлсийг 3 эрх нээж сард 600.0 мянган төгрөг жилд 7,200.0 төгрөг төлөхөөр тусгасан байна. Гэтэл уг программ хангамжийг одоогоор 2 ажилтан ашиглаж байгаа тул 2021 оны эхний хагас жилийн үйлчилгээний хөлс 2,400.0 мянган төгрөг байхаар тооцоо хийж болох байсан. Энэ оны тайланд 2021 оны 7 дугаар сараас программ хангамж ашигласны төлбөр 3,600.0 мянган төгрөгийг зардлаар бүртгэгдэж, 2022 оны программ хангамж ашиглалтын төлбөр 7,200.0 мянган төгрөгийг“ Дата ланд технологи” ХХК-нд урьдчилан шилжүүлж санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардлаар бүртгүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” заасан заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид программ хангамж ашигласны хөлсийг төсвийн хуваарьт тусгаж, тооцож, тухай сар сард нь шилжүүлэх, төсвийн зардлыг урьдчилан шилжүүлэх талаар хууль зөрчсөн шийдвэр гаргахгүй байх талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дээрх нөхцөл байдал болон энэ тайлангийн аудитын илрүүлэлт хэсэгт тусгагдсан асуудлуудаас бусад хууль тогтоомжид нийцээгүй зүйл бидэнд ажиглагдаагүй болно.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 235.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг арилгах 2 зөвлөмжийн өгсөн ба хэрэгжилт 100% хувьтай байна.

*Хүснэгт 7 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт* /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | | 1 | | | | |
| Албан шаардлага | | | | | | | |
| Зөвлөмж | 2 | | 2 | | | | |
| Нийт дүн | 3 | | 3 | | | | |

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 79 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн хөгжлийн сангаас тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулж байгаа вакцины тарилгын үйлчилгээний хөлс түүнд бүртгэлээр тавих хяналтыг дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 130,499.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс,111,662.0 мянган төгрөгийн материаллаг алдаа зөрчилд 1 албан шаардлага, 18,837.8 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа байхгүй залруулга хийгдээгүй.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тавигдаагүй болно.

### 4.3 Албан шаардлага

5 *1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал*

Эм боох бараа материалын дансны 111,662.0 мянган төгрөгийн үлдэгдэлд тооллого хийгдээгүй, зарим эм бодис хугацаа дууссан, тоо хэмжээндээ хүрэх эсэхийг нягталж, хэмжиж үзээгүй, дансны үлдэгдэл бүртгэлээр тооллогын бүртгэл үйлдэж жилийн санхүүгийн тайланд тусгасан байна. Санхүүгийн байдлын тайлан дахь бараа материалын үлдэгдлийн дүнгээс 35130 дансны үлдэгдэл 142,914.4 мянган төгрөгийн бараа материал бүрэн байгаа эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй гэж үзлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-т "*хөрөнгө, төлбөрийн тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ.*" 12.2.1 "*жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө*", заалтыг зөрчсөн үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Тайлант онд хэмнэгдсэн 536.5 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтээс дараа онд зарцуулах бичгийн цаас худалдан авч нөөц үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45.2-т "*Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ*" заасан заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Бараа материалын үлдэгдлийг зохистой түвшинд барих, 2022 оны батлагдсан зардлаас бичгийн цаас зардал 536.5 мянган төгрөгийг хасаж буцаан төвлөрүүлэх,

***2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Дараа оны программ хангамж ашиглалтын төлбөр 7,200.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж санхүүгийн байдлын тайланд урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Программ хангамжийн үйлчилгээний төлбөрийг төсвийн хуваарьт тусган гэрээнд заасан үйлчилгээг авсны дараа тооцон олгож байх.

***3. Шатахууны бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*3.1. Илрүүлэлт:*

4. Тайлант онд зарцуулсан 11,101.3 мянган төгрөгийн шатах тослох материалын тоо хэмжээг литрээр илэрхийлэхийг ширхгээр илэрхийлсэн, нэгжийн өртгийг худалдан авсан бүтээгдэхүүний нэгжийн өртгөөр бус талоны мөнгөн дүнгээр тус тус бүртгэсэн байна. Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээс шатахууны тухай жилд худалдан авсан нэгжийн өртөг, дундаж өртөг, тайлант оны зарцуулсан хэмжээг тодорхойлоход боломжгүй, ашиглаж байгаа УАЗ 10-54 дугаартай авто машины дагалдах хуудас бүрэн бөглөгдөөгүй, сар бүрийн шатахууны тооцооны тайлан байхгүй байна. Энэ нь

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-д "*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална*" 5.1.5. "*хэмжигдэхүйц байх*" 13.1."*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*" гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Бараа материалын бүртгэлд шатахууныг литрээр, нэгжийн өртгийг тухайн өдрийн нэгжийн өртгөөр бүртгэлд тусгах, шатахууны тайлан тооцоог сар бүр үнэн зөв гаргаж анхан шатны бүртгэл хөтлөлтийг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Орхон аймгийн Мал эмнэлгийн газар | 4 | 130,499.8 | - | - | - | - | 1 | 111,662.0 | 3 | 18,837.8 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

БЭЛТГЭСЭН:

"МӨНГӨ НӨӨЦ БАЯЛАГ АУДИТ" ХХК-ИЙН

АУДИТОР: Б.БАЙГАЛ Огноо: 11/25

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР М.БЯМБАДОРЖ Огноо:

АХЛАХ АУДИТОР Л.БААСАНДОРЖ Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ЭРДЭНЭ Огноо:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР: Ц.НАРМАНДАХ Огноо: